



БОДЬ ДААТГАЛ
ЭРСДЭЛИЙГ ДАВАХ ХҮЧ

БОДЬ ДААТГАЛ

2021

**БОДЬ ДААТГАЛ ХК
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН**

АГУУЛГА

Компанийн 2021 оны үйл ажиллагааны тайлан

Бизнесийн байдал

Олон улсын эрүүл мэндийн даатгал

Давхар даатгал

Дижитал, дэвшилтэд технологи

Хүний нөөцийн бодлого

Нөхөн төлбөр

Хувьцааны мэдээлэл

Санхүүгийн байдал

Салбарын үзүүлэлт

Санхүүгийн байдлын тайлан



АЛСЫН ХАРАА

АЗИД БҮРТГЭЛТЭЙ ЕРДИЙН БОЛОН АМЬДРАЛЫН ДААТГАЛЫН КОМПАНИ БОЛНО.

2030 он гэхэд Хонконгийн хөрөнгийн биржийн 2-р самбарт бүртгэлтэй, Азид өрсөлдөгч санхүүгийн цогц хамгаалалт үзүүлэгч компани болно.



ЭРХЭМ ЗОРИЛГО

ХАМТЫН ХҮЧЭЭР ИРЭЭДҮЙГ БАТАЛГААЖУУЛНА.

Хамтын хүчээр санхүүгийн нөөцөө бүрдүүлж харилцагч бүр ирээдүйгээ төлөвлөхөд нь тусалж түүнд учирч болох эрсдэлээс хамгаалах хүчирхэг санхүүгийн компани эрсдэлийн зөвлөх болно.



ҮНЭТ ЗҮЙЛС

ХАРИЛЦАГЧ ЭРХЭМ	Харилцагчаа халамжлан сэтгэл хангалуун байлгахын төлөө нөөц боломжийг бүрэн ашиглана.
МЭРГЭЖЛИЙН БАЙХ	Мэргэжлийн ёс зүйг эрхэмлэн, ур чадвараа дайчлан олон улсын түвшинд ажиллана.
УХААЛАГ АЖИЛЛАХ	Шинийг санаачилж, бүтээмжтэй, багаар ажиллана.
ХАМТЫН ХӨГЖИЛ	Урт хугацааны тогтвортой, хамтын хөгжлийг эрхэмлэнэ.
ХАРИУЦЛАГА	Бүх түвшинд нягт нямбай, хариуцлагатай, нээлттэй байна.



КОМПАНИЙН 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Бодь даатгал ХК нь 1995 онд байгуулагдсан бөгөөд өдгөө 27 дахь жилдээ орон даяар 21 аймаг 330 сум 26 салбарт 200 гаруй ажилтан, албан хаагч, 1000 гаруй төлөөлөгчид 250 мянган харилцагчиддаа даатгалын үйлчилгээг хүргэн, тогтвортой үйл ажиллагаагаа явуулж байна.

Сүүлийн 3 жилийн турш хэрэгжүүлсээр ирсэн insurtech хөгжүүлэлтийг 2021 онд бүрэн нэвтрүүлж дуусгахаар даатгалын салбарт технологи нэвтрүүлэгч стартапп Инсур ХХК-тай хөрөнгө оруулалт хийж хамтын ажиллагааг эхлүүлж, нэгдсэн бааз, цахим оффис, CRM, цахим даатгал, цахим нөхөн төлбөрийн процессийг бүрэн нэвтрүүлэн дижитал технологийг даатгалын салбарт хэрэгжүүлэн ажиллаж байна.

Дэлхийн тэргүүлэх №1 даатгалын АХА группийн Монгол дахь төлөөлөгчөөр сонгогдож олон улсын эрүүл мэндийн даатгалын үйлчилгээг Монгол хүний эрүүл мэндийн онцлог болон санхүүгийн чадварт нийцүүлэн тогтвортойгоор нутагшуулж ажиллаж байна.




2021 онд нийт хураамжийн орлого, зардалд тооцсон нөхөн төлбөрийн дүн, давхар даатгалын хураамжийн орлогоороо салбартаа тэргүүлж, даатгалын салбарын тэргүүлэгч байр сууриа хадгалсаар байна.

БИЗНЕСИЙН БАЙДАЛ

2021 онд нэрлэсэн дүнгээр эдийн засгийн хэмжээ 37.8 их наяд төгрөгөөс 44 их наяд төгрөг хүртэл өссөн. Үүнд өрхийн хэрэглээ, засгийн газрын хэрэглээ, экспорт импортын зөрүү буюу цэвэр экспортын дүнгүүд өнгөрсөн онтой адил байсан. Харин бизнесийн байгууллагуудын бараа материал, үндсэн хөрөнгийн хөрөнгө оруулалтууд тус бүр 3-4 их наяд төгрөгөөр нэмэгдсэн нь нэрлэсэн дүнгээр эдийн засаг өсөхөд нөлөөлсөн байна.

Үндэсний статистикийн хорооны мэдээллээр 2021 онд өсөлтийн хувиар санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа, бөөний болон жижиглэнгийн худалдаа хамгийн өндөр өсөлт үзүүлсэн бол, үнийн дүнгээр уул уурхай, хөдөө аж ахуй, санхүү, даатгалын үйл ажиллагааны салбарууд хамгийн өндөр өсөлт үзүүлсэн байна.

Олон улсын байгууллагууд 2021 онд Монгол улсын бодит (инфляцийг хассан) эдийн засаг 5-7%-ийн өсөлт үзүүлэх өөдрөг төсөөлөлтэй байсан боловч Ковид-19, өндөр инфляцийн улмаас хүлээлтээс огцом буурч 1.4% өөрчлөлттэй гарлаа. 2020 онд даатгалын салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь буюу




нэвтрэлт 0.4% байсан бол 2021 онд 0.5% болж өсч 2019 оны түвшинд очсон байна. Даатгалын үйлчилгээний нэвтрэлт бага байгаа тул эдийн засгийн өсөлтөөс өндөр өсөлт үзүүлж байна. Даатгалын салбар 2020-2021 онд нийт хураамжийн 62%-ийг дотооддоо авч үлдсэн (цэвэр хураамж) байна.

“Бодь даатгал” ХК нь цахим даатгал, нөхөн төлбөр, оффисийн программууд, технологийн дэвшлүүдийг үйл ажиллагаандаа нэвтрүүлсний үр дүнд компанийн ажилчид бүгд зайнаас ажиллах, харилцагч цахимаар даатгал хийлгэх боломж бүрдсэнээр эдийн засгийн хямралыг амжилттай давахад гол нөлөө үзүүллээ. Одоогийн байдлаар 14 даатгалын бүтээгдэхүүн, нөхөн төлбөрийн процессийн 90%-иас дээш цахим болоод байна.

Энэ онд Бодь Даатгал ХК гадаадын давхар даатгагчтай нягт хамтран ажиллаж эрсдэлийг шилжүүлэх, фронт оффисоо өргөжүүлэх зэрэг үйл ажиллагаануудыг хэрэгжүүлсний үр дүнд нийт хураамжийн орлого өмнөх оноос 60%-аар өсөж, 54.3 тэрбум төгрөгт хүрсэн салбарын хураамжийн 22%-ийг эзэлж, зах зээлд эзлэх хувиар 1-д орлоо. Дотоодын даатгалын цэвэр хураамж өмнөх оноос 30%-ийн өсөлт үзүүлж 19.2 тэрбум, цэвэр ашиг 21%-аар өсч 2.3 тэрбум төгрөгт хүрлээ.

Бүтээгдэхүүнээр:	/Сая төгрөгөөр/			Бүсээр (сая төг)	/Сая төгрөгөөр/		
	FY20	FY21	YoY%		FY20	FY21	YoY%
Жолоочийн хариуцлага:	4,754.2	5,978.6	26.7%	УБ хот иргэд	5,357.4	6,984.6	30.4%
Тээврийн хэрэгсэл:	2,694.2	4,703.3	74.6%	Орон нутаг иргэд	2,304.0	2,191.4	-4.8%
Эрүүл мэнд:	3,964.8	3,812.5	-3.8%	Нийт иргэд:	7,661.4	9,176.0	19.8%
Хөрөнгө:	963.5	1,481.2	53.7%	Хөрөнгө, хариуцлага:	2,854.0	3,886.2	36.1%
Хариуцлага:	1,347.7	1,498.5	11.2%	Эрүүл мэнд:	3,202.0	3,504.4	9.4%
Мал амьтад:	574.2	585.4	1.9%	Шууд бус (Брокер):	951.0	2,589.7	172%
Бусад:	369.9	1,096.8	2%	Байгууллага нийт:	7,007.0	9,980.3	41%
Цэвэр хураамж	14,668.4	19,156.3	30.6%	Цэвэр хураамж:	14,668.4	19,156.3	30.6%

Хөдөө орон нутгийн 21 салбараар дамжуулан борлуулсан бүтээгдэхүүнээс хамгийн их хувийг малын индексжүүлсэн даатгал эзэлдэг бөгөөд 2021 онд компани тус бүтээгдэхүүний салбарын хураамжийн 22%-ийг бүрдүүлсэн байна.



ОЛОН УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ

BOD+
Global Healthcare

Бодь Даатгал ХК-ийн хамт олон та бүхэнд эрүүл мэндийн даатгалын салбарт 80 жилийн туршлагатай AXA Health and Life Reinsurance Solutions даатгалын компанитай хамтран гаргасан “BODI+ Global Healthcare” бүтээгдэхүүн нь эрүүл мэндийн тэргүүлэгч бүтээгдэхүүн бөгөөд 2015 оноос харилцагч байгууллага болон даатгуулагчдын итгэлийг хүлээн ажиллахын зэрэгцээ AXA хамтын ажиллагааг улам өргөжүүлэн, андеррайтингийн шинэ боломжийг нээн ковид эмчилгээний зардлыг даатгуулагчдадаа олгож байна.

Мөн эрүүл мэндийн даатгалын үйлчилгээнээс гадна аливаа өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Хэрэглээний сэтгэл судлалын хүрээлэнтэй хамтарч сэтгэл зүйн эрүүл мэндийн ач холбогдол, эрүүл тэнцвэртэй хоол зүйн сургалт, эмчийн зөвлөгөө, байгууллагын ажилтнуудын өвчлөлд тулгуурласан мэргэжлийн эмчийн зөвлөгөө, фитнес клубын хөнгөлөлт гэх мэт олон халамжийн хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байна.



Дэлхий даяар 12 мянган эмнэлгийн сүлжээнд холбогдсон шууд төлбөрийн үйлчилгээ



Салбартаа олон жил ажилласан туршлагатай нөхөн төлбөрийн зөвлөх эмч



Эрүүл мэндийн даатгалын чиглэлээр мэргэшсэн даатгалын андеррайтингийн баг



Таны эрүүл мэнд болон хувийн нууцлалыг дэлхийн түвшний өндөр стандартаар хамгаална.



Урьдчилан сэргийлэх үзлэгийн хамгаалалт



Таны эрүүл амьдралын хэв маягт дэмжлэг үзүүлэх халамжийн бодлого

ДАВХАР ДААТГАЛ

2021 онд бид даатгалын салбарт туршлагатай, өндөр ур чадвар бүхий мэргэшсэн баг хамт олон, давхар даатгалын хэлтсийг шинээр байгуулан харилцагчийн эрсдэлийг шууд болон салбарын зах зээл дээр нэр хүнд бүхий, дэлхийд тэргүүлэгч давхар даатгалын брокеруудаар дамжуулан олон улсын зах зээл дээр амжилттай байршуулан 2021 оны төлөвлөгөөгөө 188% биелүүлсэн ололт амжилттай ажиллалаа:

- Компани стратегийн ач холбогдолтой томоохон төслүүдэд анхдагч даатгалын үйлчилгээ үзүүлэгч болж, тэдгээрийн эрсдэлийг гадны зах зээл дээр хүсэлт, шаардлагын дагуу амжилттай байршуулан, даатгалтай холбогдолтой бүхий л техник туслалцааг үзүүлэн ажиллаж байна.
- Бид агаарын хөлгийн иж бүрэн даатгалыг олон улсын А болон түүнээс дээш зэрэглэлтэй зах зээл дээр дэлхийд эхний 3-т багтдаг томоохон давхар даатгалын брокероор дамжуулан амжилттай байршуулан, харилцагчид шаардлагатай техник туслалцааг цаг алдалгүй үзүүлэн ажиллаж байна.
- Хэдийгээр компани гэрээт давхар даатгалын хамгаалалтаа улам нэмэгдүүлэхээр төлөвлөж байсан хэдий ч Ковид19-өөс үүдэлтэй эдийн засгийн тогтворгүй байдлаас болоод тодорхойгүй нөхцөлөөс шалтгаалан 2020 оны хамгаалалтаа хэвээр үргэлжлүүлэх шийдвэр гарган ажилласан ба бид үүнийг нөхцөл байдалдаа тохирсон оновчтой шийдвэрүүдийн нэг гэж харж байна.

Хамтран ажилладаг брокерууд

 Aon

 MARSH

 Willis


 LLOYD'S

 LOCKTON


 JLT

 UlysseRe

 UIB

Хамтран ажилладаг давхар даатгагчид**АНДЕРРАЙТЕР**

- Азийн зах зээлд бүртгэлтэй компани болох алсын хараа, зорилгын хүрээнд эрсдэлийн бодлогын чухал хэсэг болох андеррайтингийн үйл ажиллагааг дэлхийн томоохон андеррайтер компаниудын хэрэгжүүлж дагаж мөрддөг стандарт, бодлоготой нийцүүлэн андеррайтингийн мэргэжлийн баг бүрдүүлж ажиллаж байна.
- Андеррайтингийн бодлогын баримт бичгийг олон улсын даатгалын салбарын чиг хандлага, стандартад нийцүүлэн боловсруулж, даатгалын гэрээний нөхцөл, хохирлын харьцаан дээр суурилсан үнэ хамгаалалтын зохистой харьцаа бүхий бүтээгдэхүүн үйлчилгээг олон төрлийн харилцагчийн халамж ба нэмэлт хамгаалалт санал болгон, байнга сайжруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.
- Нийгэм, эдийн засгийн бүх л салбарын бизнесийн байгууллагын үйл ажиллагааны онцлогийг харгалзсан бүтээгдэхүүн үйлчилгээн дээр төвлөрөн зохицуулах байгууллагын хууль, дүрэм журамд нийцүүлэн үйл ажиллагаандаа мөрдлөг болгон оновчтой андеррайтингийн бодлогыг иргэд ба байгууллагын харилцагчдад хүргэж байна.
- Санхүү, эрсдэлийн удирдлагын газартай хамтран эрсдэлийн матрицыг улирал тутам хөтлөн үүсч болох эрсдэлийн магадлал, учирч болзошгүй хохирлын үр дагаврыг урьдчилан, таамаглан тооцоолж үйл ажиллагаанд учирч болох эрсдэлийн үнэлгээг тогтмол хийж байна.
- Андеррайтингийн автоматжуулалт үүнтэй холбоотой технологийн шийдлийг хөгжүүлэх, монголын даатгалын зах зээлд эдгээрийг нэвтрүүлэхээр зорин ажиллаж байна.




ДИЖИТАЛ, ДЭВШИЛТЭД ТЕХНОЛОГИ

Бодь Даатгал ХК салбартаа даатгалын дижитал технологийг нэвтрүүлж эхэлсэн бөгөөд энэ нь цар тахлын хөл хорионы нөхцөл байдал үүсэхэд цахим шилжилт эхлүүлсний дүнд компанийн дотоод үйл ажиллагаа, зайнаас ажиллах нөхцөл боломж, даатгалын үйл ажиллагааг зайнаас цахимаар хийх, мөн нөхөн төлбөрийн үйл ажиллагааг аппликэйшн –ээр хийх зэргээр бүх процесс хэвийн үргэлжилж, компанийн хэмжээнд цар тахлын хүндхэн үеийг харилцагчдынхаа хамтаар эрсдэл багатайгаар даван тууллаа.

Энэхүү дэвшилтэт технологийг нэвтрүүлсний дүнд хэрэглэгчид даатгал хийлгэхдээ байгаа газраасаа <https://bodi-insurance.com/products-online/> сайт руу хандан даатгалын мэдээллээ оруулж, төлбөрөө хийн даатгалын баталгаажсан гэрээгээ хүлээн авснаар хурдан шуурхай үйлчилгээ авах боломж бий боллоо. Мөн хамгийн чухал нөхөн төлбөрийн процессийг 2019 оноос эхлэн зайнаас газар дээр нь 20 минут орчим дундаж хурдтайгаар шийдвэрлэж эхэлсэн бол 2021 онд нөхөн төлбөрийн үйл ажиллагааг улам сайжруулан аппликэйшн хөгжүүлснээр хэрэглэгчид зам тээврийн ослын тохиолдолд замын цагдаа, даатгалын ажилтанг хүлээх, бичиг баримт бүрдүүлэх, үнэлгээ хийлгэх, нөхөн төлбөрийн шийдвэр авах зэргээр хэдэн өдрөөр үргэлжилдэг байсан бүх процессийг цахим болгож, 10-20 минутанд бүрэн шийдвэрлэж байна.

Одоогоор 14 даатгалыг цахимаар хийж, нөхөн төлбөрийн үйл ажиллагааг осол гарснаас эхлээд харилцагчийн дансанд нөхөн төлбөр орох хүртэлх бүх процессийг bodi claim аппликэйшн-ээр бүрэн шийддэг боллоо.





ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО


Компанийн бүтээмжийг нэмэгдүүлж, үйл ажиллагааг оновчтой зохион байгуулахын тулд хүний нөөцийн дунд хугацааны стратегийн хүрээнд дараах хөтөлбөрүүдийг хэрэгжүүллээ:

- Фронт оффисоо өргөжүүлэх төлөвлөгөөний хүрээнд даатгалын мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөр хэрэгжүүлж, сургалтанд хамруулах, цалинтай дадлагжуулахын зэрэгцээ багийн шинэчилсэн бүтэц зохион байгуулалтыг хийлээ. Мөн нийт ажилтнуудад компанийн үнэт зүйлтэй уялдсан суурь ур чадварын сургалтуудыг мэргэжлийн зөвлөх компанитай хамтран онлайн хэлбэрээр зохион байгууллаа.
- Компанийн залгамж халаа бэлтгэх болон ажилтны хувийн хөгжилд анхаарч олон улсын түвшинд ажиллах чадвар бүхий, мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэх, дадлагажуулахад онцгойлон анхаарч сургалт, хөгжлийн нэгдсэн бодлого боловсруулж амжилттай хэрэгжүүлж, олон улсын мэргэшсэн даатгалын (CII) түвшний сургалтанд хамрагдуулан, шалгалтанд тэнцсэн ажилчдаа ур чадварын нэмэгдэлд хамрууллаа.
- Бизнесийн үйл ажиллагааны өгөөж, бүтээмжийг бодит, өндөр түвшинд хүргэх мөн цар тахлын нөхцөл байдалтай зохицуулалт хийн уян хатан цагийн хуваарь, мөн ажлын байрны онцлогоос шалтгаалсан зайнаас, hybrid холимог, оффист гэсэн сонголттойгоор ажилладаг боллоо.
- Ажилтны ажиллах орчин, хамт олны нэгдмэл байдлыг нэмэгдүүлэх олон арга хэмжээ зохион байгуулсны томоохон нь оффисийн засвар тохижилт хийж, ажилчиддаа эрүүл мэндийн даатгалын хөнгөлөлт олгон даатгалд хамрууллаа.

НӨХӨН ТӨЛБӨР

2021 онд нийт 10.7 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийн 14 хувь буюу 1.5 тэрбум төгрөгийг давхар даатгагч, үлдсэн 8.9 тэрбум төгрөгийг компани өөрөө хариуцан төлсөн байна. Компанийн 2021 оны хохирлын харьцаа өмнөх оныхоос 13 хувиар өсч 51 хувьд хүрчээ.

ЦЭВЭР ХУРААМЖИД НОГДОХ НӨХӨН ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ /ХАРЬЦУУЛАЛТ/




“
2021 онд нийт 15,493 даатгуулагчид 10.7 тэрбумын нөхөн төлбөр олгосон байна.
”

Өсөлтийн үзүүлэлтийг даатгалын хэлбэрээр задлан харвал гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал, авто тээврийн хэрэгслийн даатгал, хөрөнгийн даатгалын хохирлын харьцаанууд өссөн харагдаж байна. Бид 2022 онд хөрөнгийн болон гэнэтийн ослын даатгалын хохирлын харьцааг зохистой түвшинд хадгалахын тулд эрсдэлийн үнэлгээ, эрсдэл бууруулах ажлуудыг даатгуулагч нартай хамтарч хэрэгжүүлэх мөн эрсдэлийн удирдлагын чиглэлээр сургалтын хөтөлбөр боловсруулж даатгуулагч нарт санал болгохоор ажиллаж байна.

/Сая төгрөгөөр/

Зардалд тооцсон нөхөн төлбөрийн дүн	2020	2021	Өсөлт
Жолоочийн хариуцлагын даатгал	2.279.35	4,201.99	84.4%
Авто тээврийн хэрэгслийн даатгал	1.663.89	2,070.00	24.4%
Гэнэтийн осол, эмчилгээний даатгал	1.875.65	1.620.30	-13.6%
Мал амьтдын даатгал	254.24	409.48	61.1%
Хөрөнгийн даатгал	214.91	317.78	47.9%
Хариуцлагын даатгал	180.60	228.70	26.6%
Бусад	195.28	15.43	-92.1%
Нийт	6.663.93	8.671.85	30.1%



ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

2020 оны 5 сард Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан IPO (Initial Public Offering) хийж, олон нийтэд компанийн нийт хувьцааныхаа 15 хувийг санал болгон нийт 5.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг амжилттай татан төвлөрүүлж олон нийтэд нээлттэй компани болсон.

Үзүүлэлт	Тийм
Самбар:	MSE I
Орсон индекс:	ТОП 20
Хяналт, зохицуулалт:	СЗХ, Хөрөнгийн бирж, Аудит
Орлого, ашиг сүүлийн 3 жилд дараалж өссөн эсэх:	тийм
Эдийн засгийн уналтаас хамаарал:	Бага
Шинэ оролцогчийн эрсдэл:	Тусгай зөвшөөрөлтэй, зохицуулалттай салбар
Менежментийн туршлага:	Гүйцэтгэх удирдлага, даатгалын захирал 10 -аас дээш жил ажилласан.

Хаалтын ханш 2021/12/31			154.52 төгрөг	
EPS 2021	P/E харьцаа	P/B харьцаа	ROA /нийт хөрөнгийн өгөөж/	ROE /өөрийн хөрөнгийн өгөөж/
10.24	15.7	2.0	5.04%	15.86%



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Бодь Даатгал компанийн дүрэмд тусгагдсанаар ТУЗ нь 9 гишүүнтэй байхаас 3 нь хараат бус гишүүн байх бөгөөд гишүүдийн бүрэн эрхийн хугацаа нь 3 жил үргэлжилнэ. 2020 оны 9 сарын 12-ны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын санал хураалтын үр дүнд үндэслэн “Бодь даатгал” компанийн ТУЗ-ийн гишүүнээр дараах хүмүүсийг томилсон байна.



Л.БОЛДХУЯГ
ТУЗ-ын дарга



Г.САРУУЛ
ТУЗ-ын гишүүн



Ш.СҮХБААТАР
ТУЗ-ын гишүүн



Д.ДАЯНБИЛГҮҮН
ТУЗ-ын гишүүн



Б.БИЛЭГТ
ТУЗ-ын гишүүн



Ш.БЭЖИД
ТУЗ-ын гишүүн



Э.БЯМБАЖАВ
ТУЗ-ын хараат бус
гишүүн



Б.ЭРДЭНЭБАТ
ТУЗ-ын хараат бус
гишүүн



Б.БҮЖИНЛХАМ
ТУЗ-ын хараат бус
гишүүн

САНХҮҮГИЙН БАЙДАЛ

Бодь даатгал ХК цэвэр хураамжийн дүнгээр 2020 онд 4-р байранд орж байсан бол 2022 онд эхний 3-т орсон байна. Зуучлалын зардлаа хасч үзвэл эхний 3 компани ойролцоо дүнтэй цэвэр орлого олсон байна.


Бодь даатгалын зуучлалын зардал, үйл ажиллагааны зардлын харьцаа салбарын дунджаас бага боловч хохирлын харьцаа буюу нөхөн төлбөр олголт салбарын дунджаас өндөр тул даатгалын үйл ажиллагаанаас ашиг багатай ажиллалаа. Хосолсон харьцаа буюу нөхөн төлбөр, үйл ажиллагааны зардлаа орлогод тооцсон хураамжтай харьцуулсан харьцаа салбарын дундаж 105%, Бодь 119% байна. Өөрөөр хэлбэл Даатгалын үйл ажиллагаанаас 19% алдагдалтай гарсан. Бодь даатгалын зардлын харьцаа салбарын дундажаас 10%-иар өндөр байгаа нь энэ зөрүүг үүсгэж байна. 2022 онд зардлын харьцаануудыг бууруулах бизнес төлөвлөгөөтэй ажиллаж байна.

(Тэрбум төгрөг)	Бодь даатгал	Эзлэх хувь	Салбарын нийт (Бодь даатгал ороогүй)	Эзлэх хувь
Орлогод тооцсон хураамж	17.1	100%	120.5	100%
Нөхөн төлбөр	8.2	48%	52.0	43%
Үйл ажиллагааны зардал	9.6	56%	55.6	46%
Зуучлалын зардал	2.5	15%	18.3	15%

Харин давхар даатгалын хураамжаар салбартаа тэргүүлж байна. Хөрөнгө оруулалтын хувьд эрсдэл бага авах, тогтвортой байх бодлоготой тул хөрөнгө оруулалтын өгөөж салбарын дундажтай ойролцоо гарсан. Давхар даатгалын шимтгэлээр 3.0 тэрбум, хүүгийн орлогоос 1.9 тэрбум нийтдээ 2.6 тэрбум төгрөгийн нийт орлоготой ажилласнаас 0.3 татвар шимтгэл төлж 2.3 тэрбумын цэвэр ашигтай гарлаа. Энэ нь эздийн өмчийн 15.86%-ийг эзэлж байна. Цаашид 2022 онд эдийн засгийн байдал хэвийн өсөлттэй үргэлжилбэл, технологийн нэвтрүүлэлт зардлын хэмнэлтийн үр дүнгээ өгч эхэлснээр зардлын харьцаа буурч, ашигт ажиллагаа огцом нэмэгдэх дүр зурагтай байна.

САЛБАРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД (2021 он, тэрбум төгрөг)


НИЙТ ХУРААМЖ




ЦЭВЭР ХУРААМЖ




ЗАРДАЛД ТООЦСОН НӨХӨН ТӨЛБӨР



ЦЭВЭР АШИГ




НИЙТ ХӨРӨНГӨ




ЦЭВЭР ХӨРӨНГӨ




ОРЛОГОД ТООЦСОН ХУРААМЖ




НИЙТ ЗАРДАЛ




ЗАРДЛЫН ХАРЬЦАА




ЗУУЧЛАЛЫН ЗАРДЛЫН ХАРЬЦАА



ХОХИРЛЫН ХАРЬЦАА



ХОСОЛСОН ХАРЬЦАА



САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

№	Үзүүлэлт	2021 оны 01 сарын 01	2021 оны 12 сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө		
1.1.1	Бэлэн мөнгө	5,337,044.88	5,404,969.22
1.1.2	Харилцах	361,403,608.48	1,084,485,512.06
1.1.3	Банк санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	0.00	0.00
1.1.4	Мөнгөн хөрөнгөнд хуримтлуулж тооцсон хүүний авлага	0.00	0.00
1.1.5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн дүн	366,740,653.36	1,089,890,481.27
1.2	Даатгалын авлага		
1.2.1	Даатгалын хураамжийн авлага /цэвэр дүнгээр/	2,554,544,390.80	7,049,431,602.90
1.2.2	Буруутай этгээдээс авах авлага /цэвэр дүнгээр/	976,197,340.07	488,780,292.01
1.2.3	Давхар даатгалаас авах авлага /цэвэр дүнгээр/	0.00	0.00
1.2.4	Даатгалын авлагын дүн	3,530,741,730.87	7,538,211,894.91
1.3	Бусад санхүүгийн хөрөнгө	0.00	
1.3.1	Бусад авлага /цэвэр дүнгээр/	3,657,459,788.08	2,874,188,310.53
1.3.2	Бусад санхүүгийн хөрөнгийн дүн	3,657,459,788.08	2,874,188,310.53
1.4	Бусад санхүүгийн бус хөрөнгө	0.00	
1.4.1	НДШ авлага, бусад татварын авлага	6,082,575.82	14,148,736.87
1.4.2	ААНОАТатварын авлага	0.00	0.00
1.4.3	Хойшлогдсон татварын хөрөнгө	5,978,793.80	0.00
1.4.4	Бараа материал	85,372,341.19	55,251,964.32
1.4.5	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	973,329,623.14	1,592,199,511.08
1.4.6	Өмчлөх бусад хөрөнгө /цэвэр/	50,000,000.00	0.00
1.4.7	Бусад санхүүгийн бус хөрөнгийн дүн	1,120,763,333.95	1,661,600,212.26
1.5	Хөрөнгө оруулалт		
1.5.1	Хадгаламж, хадгаламжийн сертификат	11,491,084,787.43	6,576,595,638.04
1.5.2	Үнэт цаас /цэвэр/	2,276,055,154.90	6,296,562,722.61
1.5.3	Хараат ба хамтын хяналттай, охин компаниудад оруулсан хөрөнгө	0.00	400,000,000.00
1.5.4	Үнэт металл, Дериватив	0.00	0.00
1.5.5	Хөрөнгө оруулалтын дүн	13,767,139,942.33	13,273,158,360.65
1.6	Даатгалын хөрөнгө		
1.6.1	ДД-ын хойшлогдсон хураамж	7,477,418,126.31	15,261,357,182.54
1.6.2	Нөхөн төлбөрийн нөөцийн ДД-ын ногдох хэсэг	218,383,186.78	131,540,115.78
1.6.3	Даатгалын орлогын шимтгэлийн хойшлогдсон зардал	1,006,240,642.56	1,484,535,335.02
1.6.4	Даатгалын хөрөнгийн дүн	8,702,041,955.65	16,877,432,633.34
1.7	Үндсэн хөрөнгө /Цэвэр/	1,416,556,188.87	1,370,463,218.19
1.8	Биет бус хөрөнгө /Цэвэр/	113,589,285.00	89,391,247.41
1.9	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	0.00	0.00
1.10	Нийт хөрөнгийн дүн	32,675,032,878.11	44,774,336,358.56
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	0.00	

2.1	ӨР ТӨЛБӨР	0.00	
2.1.1	Даатгалын өглөг	0.00	
2.1.1.1	Даатгалын хураамжийн буцаалтын өглөг	0.00	0.00
2.1.1.2	Даатгалын гэрээний шимтгэлийн өглөг	154,347,612.92	138,360,775.35
2.1.1.3	ДД өгөх өглөг	741,860,315.33	3,081,817,773.30
2.1.1.4	Даатгалын өглөгийн дүн	896,207,928.25	3,220,178,548.65
2.1.2	Бусад санхүүгийн өр төлбөр	0.00	
2.1.2.1	Зээлийн өглөг, хүү	0.00	133,956,207.89
2.1.2.2	Өрийн бичиг, хүү	0.00	0.00
2.1.2.3	Санхүүгийн түрээсийн өр төлбөр	0.00	0.00
2.1.2.4	Ногдол ашгийн өглөг	0.00	0.00
2.1.2.5	Деривативын өр төлбөр	0.00	0.00
2.1.2.6	Бусад өр төлбөр	786,821,596.47	840,534,554.64
2.1.2.7	Бусад санхүүгийн өр төлбөрийн дүн	786,821,596.47	974,490,762.53
2.1.3	Бусад санхүүгийн бус өр төлбөр	0.00	
2.1.3.1	Цалингийн өглөг	67,874,030.07	85,128,851.39
2.1.3.3	НДШ-ийн өглөг	23,073.61	0.00
2.1.3.2	ХХОАТ-ын өглөг	86,877,733.22	116,340,683.84
2.1.3.4	ААНОАТатварын өглөг	82,423,750.72	8,109,990.62
2.1.3.5	Хойшлогдсон татварын өглөг	36,674,010.79	17,043,885.82
2.1.3.6	Урьдчилж орсон орлого	449,986,757.76	698,856,177.80
2.1.3.7	Нийгмийн хөгжлийн сангийн өр төлбөр	0.00	0.00
2.1.3.8	Хуулийн байууллагаар шийдэгдэж байгаа зүйлсийн өр төлбөр	0.00	0.00
2.1.3.9	Мөнгөөр төлөгдөх хувьцааны опцион	0.00	0.00
2.1.3.10	Тэтгэврийн сангийн өр төлбөр	0.00	0.00
2.1.3.11	Санхүүгийн түрээсийн хэрэгжээгүй орлого	0.00	0.00
2.1.3.12	Бусад санхүүгийн бус өр төлбөр	0.00	0.00
2.1.3.13	Бусад санхүүгийн бус өр төлбөрийн дүн	723,859,356.17	925,479,589.48
2.1.4	Хоёрдогч өглөг	0.00	0.00
2.1.5	Давуу эрхийн хувьцаа (хөрвөхгүй)	0.00	0.00
2.1.6	Орлогод тооцоогүй хураамжийн нөөц	13,314,770,772.01	23,193,505,137.62
2.1.7	Нөхөн төлбөрийн нөөц сан	0.00	
2.1.7.1	Учирсан боловч мэдэгдээгүй ХНС	798,816,494.93	607,073,012.08
2.1.7.2	Мэдсэн боловч төлөөгүй ХНС	658,533,182.49	443,968,447.00
2.1.7.3	Учирч болзошгүй ХНС	755,330,765.93	1,399,414,012.14
2.1.7.4	Хоорондын тооцоо	0.00	0.00
2.1.7.5	Тусгай нөөц сан	1,179,112,279.31	733,522,279.31
2.1.7.6	Нөхөн төлбөрийн нөөц сангийн дүн	3,391,792,722.66	3,183,977,750.53
2.1.8	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	19,113,452,375.56	31,497,631,788.80
2.2	ЭЗДИЙН ӨМЧ	0.00	
2.2.1	Эзэмшигчдийн өмч	5,882,975,000.00	5,882,975,000.00
2.2.2	Халаасны хувьцаа	0.00	-17,082,625.00
2.2.3	Нэмж төлөгдсөн капитал	2,193,308,786.86	2,339,864,176.35
2.2.4	Тогтвортой байдлын нөөц сан	0.00	0.00
2.2.5	Хөрөнгийн дахин үнэлгээний өөрчлөлт	304,850,309.69	99,974,033.69
2.2.6	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	0.00	0.00
2.2.7	Эздийн өмчийн бусад хэсэг	0.00	0.00
2.2.8	Хуримтлагдсан ашиг, алдагдал	5,180,446,406.00	4,970,973,984.72
2.2.9	ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	13,561,580,502.55	13,276,704,569.76
2.3	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	32,675,032,878.11	44,774,336,358.56

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

№	Үзүүлэлт	2021 оны 01 сарын 01	2021 оны 12 сарын 31
	Даатгалын үйл ажиллагаа		
	Даатгалын хураамжийн нийт орлого	33,816,919,212.94	54,312,598,392.74
	Даатгалын хураамжийн буцаалт (-)	611,126,452.93	601,900,201.67
	Давхар даатгалын хураамжийн зардал (-)	18,537,396,193.72	34,554,432,495.35
	Даатгалын хураамжийн цэвэр орлого (мөр5=мөр(2+3+4))	14,668,396,566.29	19,156,265,695.72
	Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн өөрчлөлт (+,-)	-2,009,774,386.83	9,878,734,365.61
	Давхар даатгалын хойшлогдсон хураамжийн өөрчлөлт (+,-)	1,918,136,023.87	-7,783,939,056.23
	Орлогод тооцсон хураамж (5-6-7)	14,760,034,929.25	17,061,470,386.34
	Нийт нөхөн төлбөрийн зардал	8,583,285,540.60	10,740,187,699.06
	Давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөр (+)	2,039,225,970.73	1,528,655,132.86
	Буруутай этгээдийн хариуцсан нөхөн төлбөр (+)	515,542,171.45	226,876,664.54
	Нөхөн төлбөрийн цэвэр зардал (9-10-11)	6,028,517,398.42	8,984,655,901.66
	Нөхөн төлбөрийн нөөц сангийн өөрчлөлт (+,-)	401,347,068.08	-851,898,218.34
	Нөхөн төлбөрийн нөөц сангийн давхар даатгагчид ногдох хэсгий	9,785,492.61	86,843,071.00
	Учирч болзошгүй хохирлын нөөц сангийн өөрчлөлт (+,-)	224,275,238.93	644,083,246.21
	Зардалд тооцсон нөхөн төлбөр (12+13+14+15)	6,663,925,198.04	8,863,684,000.53
	Даатгалын гэрээний зардал (-)	-2,150,632,737.50	-2,482,018,218.48
	Давхар даатгалын шимтгэлийн орлого (+)	1,158,455,890.59	3,034,646,841.70
	Хөрөнгө оруулалтын олз, гарз (+,-)	1,524,926,022.59	1,953,849,838.30
	Даатгалын үйл ажиллагааны ашиг(алдагдал)(8-16+17+18+19)	8,628,858,906.89	10,704,264,847.33
	Түрээсийн орлого (+)	6,773,000.00	9,982,887.00
	Хүү, Эрхийн шимтгэлийн орлого (+)	54,909,493.74	45,023,870.93
	Бусад орлого (+)	340,753,546.40	65,435,534.76
	Ерөнхий ба удирдлагын зардал (-)	3,180,204,765.64	4,082,000,939.83
	Борлуулалт, маркетингийн зардал (-)	3,318,451,963.23	4,234,135,868.29
	Санхүүгийн зардал (-)	15,649,166.23	92,822,062.51
	Бусад зардал (-)	151,113,838.48	1,252,434,830.93
	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) (+,-)	-27,390,562.60	-1,429,412.96
	Биет болон биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз) (+,-)	-9,384,394.55	-66,499,999.95
	Бусад ашиг (алдагдал) (20+21+...+29)	-6,299,758,650.59	-9,608,880,821.77
	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал) (20+30)	2,329,100,256.30	1,095,384,025.56
	Орлогын албан татварын зардал	257,880,033.76	231,463,245.84
	Татварын дараах ашиг (алдагдал) (31-32)	2,071,220,222.54	863,920,779.72
	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал) (+)		
	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) (33+34)	2,071,220,222.54	863,920,779.72
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад		
	Орлогын нийт дүн (35+36+37+38)	2,071,220,222.54	863,920,779.72
	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

№	Үзүүлэлт	2021 оны 01 сарын 01	2021 оны 12 сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	34,236,250,725.96	50,150,602,436.79
1.1.1	Даатгалын хураамжийн орлого	32,933,595,576.11	45,491,896,205.31
1.1.2	Давхар даатгалын нөхөн төлбөр	1,143,222,911.54	185,381,994.89
1.1.3	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
1.1.4	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	136,167,106.04	233,913,103.79
1.1.5	Буцаан авсан албан татвар		
1.1.6	Татаас, санхүүжилтийн орлого	5,950,000.00	8,165,186.60
1.1.7	Бусад мөнгөн орлого	17,315,132.27	4,231,245,946.20
1.2	Мөнгөн зарлагын дүн(-)	37,543,689,029.56	49,203,091,351.85
1.2.1	Ажиллагчдад төлсөн	2,120,376,704.40	2,407,007,418.29
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	257,950,736.51	636,895,220.40
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	295,476,850.00	
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	466,133,586.12	661,010,104.95
1.2.5	Давхар даатгагчид төлсөн давхар даатгалын хураамж	20,950,538,295.33	26,503,016,491.66
1.2.6	Нөхөн төлбөрт төлсөн	8,373,759,100.64	10,545,441,855.50
1.2.7	Үүнээс: Сайн дурын даатгалын	5,898,789,141.64	7,275,553,351.10
1.2.8	Албан журмын даатгалын	2,474,969,959.00	3,269,888,504.40
1.2.9	Даатгалын төлөөлөгчийн шимтгэл	1,379,050,111.06	1,396,385,939.15
1.2.10	Даатгалын зуучлагчид төлсөн төлбөр	752,141,151.39	1,417,554,660.52
1.2.11	Даатгалын хохирол үнэлэгчид төлсөн төлбөр		
1.2.12	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	106,627,121.00	88,506,612.50
1.2.13	Хүүний төлбөрт төлсөн		
1.2.14	Татварын байгууллагад төлсөн	585,070,196.75	772,548,818.62
1.2.15	Даатгалын төлбөрт төлсөн		
1.2.16	Бусад мөнгөн зарлага	2,256,565,176.36	4,774,724,230.26
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(3,307,438,303.60)	947,511,084.94
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	637,429,361.49	1,723,916,689.23
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	9,925,000.00	
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
2.1.3	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БОРЛУУЛСНЫ ОРЛОГО		221,640,852.90
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	72,454,358.00	107,200,000.00
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	555,050,003.49	1,395,075,836.33
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	151,523,813.33	6,638,717,995.90
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	146,623,813.33	263,123,467.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	4,900,000.00	
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		6,175,594,528.90
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		200,000,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	485,905,548.16	(4,914,801,306.67)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	6,638,224,672.00	8,870,161,499.38
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	360,000,000.00	2,683,374,000.00
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	960,000,000.00	
3.1.3	Төрөл бүрийн хандив		
3.1.4	Бусад	5,318,224,672.00	6,186,787,499.38
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	4,199,482,440.03	4,179,721,449.74
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	2,208,805,875.03	2,719,104,702.45
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		57,143,771.79
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	461,120,647.00	788,448,000.00
3.2.4	Төлсөн ногдол ашиг		615,024,975.50
3.2.5	Бусад	1,529,555,918.00	
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	2,438,742,231.97	4,690,440,049.64
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(382,790,523.47)	723,149,827.91
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	749,531,176.83	366,740,653.36
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	366,740,653.36	1,089,890,481.27



БОДЬ ДААТГАЛ
ЭРСДЭЛИЙГ ДАВАХ ХҮЧ

📍 15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3,
Ц.Жигжиджавын гудамж-9, Сүхбаатарын талбай, Бодь Цамхаг

☎ +976-7000 4800

✉ bodi@bodi-insurance.com

🌐 Вэб: www.bodi-insurance.com